

№ 14 / 2021 оны 5-р сар

Ирээдүйг хамтдаа бүтээе

2020 оны 7-р сарын 11-нд ГИДЦГ-ын "Б" хэсэгт 300 дахь тахь мэндэлсэн. Түүний эхийг Дороти гэх бөгөөд ОУТГ-ийн хүндэт гишүүн, ивээн тэтгэгч Дороти Штаммын нэрээр нэрлэсэн юм. Энэхүү гүү нь 1999 онд тахийг сэргээн нутагшуулж эхэлснээс хойшхи тусгай хамгаалалттай газар нутагт төрсөн анхны унага байв. Аравдугаар сарын дундуур байгаль хамгаалагчид 320 тахь тоолсны 70 хувь нь нөхөн үржих боломжтой гүү байсан нь 50 жилийн өмнө зэрлэг байгальд устаж үгүй болсон энэ амьтанд цаашид нөхөн үржих таатай нөхцөл бүрдсэн гэж үзжээ.



Зургийг С.Далайцэрэн

Зэрлэг адуу болон түүний амьдрах орчныг хамгаалцгаая.

Хайрт тахийн эрхэм анд нар аа,



Анхдагч зэрлэг адууг хамгаалан авч үлдэх ажилд санаа тавьдаг хүмүүст энэ зэрлэг амьтны төрөл зүйл нь тал нутгийн бусад туруутан амьтдын адил хамгаалахад онцгой сорилт болж байгааг тайлбарлах шаардлагагүй юм. Хэдийгээр тэд хатуу ширүүн амьдралын нөхцөлд дасан зохицсон боловч хангалттай хэмжээний ус, тэжээл

олохын тулд өргөн уудам нутаг хамарсан нүүдэл хийдэг. Учир нь тэдэнд шаардлагатай тэжээлийн нөөц нь цаг агаараас их хамааралтай байдаг юм. Усны эх үүсвэр хурдан ширгэж, хүрээлэн буй орчны өвс ургамал хатаж гандах магадлал их тохиолддог. Иймд тэдгээр нь мэнд үлдэхэд шаардлагатай хэрэгцээт орчин руу нүүдэл хийх боломжтой байх нь зүйтэй юм. Тийм учраас нилээд хэдэн том газар нутгийг хамгаалалтанд авч хооронд нь холбох нь маш чухал юм.

Гэхдээ өнөө цагт хүн ганцаараа бүх хөхтөн амьтдаас арав дахин их биомасс, мал сүрэг нь бусад зэрлэг хөхтөн, шувуудыг нийлүүлснээс арав дахин их биомасс эзэлдэг тул маш том хэмжээний хамгаалалттай газар нутаг шаардлагатай - энэ нь боломжгүй юм. Мөн онцгой тохиолдолд тооцогдох Зүүнгарын говь мэт цөөн хүн амьдардаг газар нутагт ч адил. Тэнд эрт дээр үеэс нүүдэлчид амьдран мал сүргийнхээ бэлчээр болгон ашиглаж ирсэн. Тиймээс ГИДЦГ-ын "Б" хэсэг бол ЮНЕСКО-гийн шим мандлын нөөц газарт хамаарагддаг. Энд хүмүүс байгальд хор хөнөөлгүйгээр уламжлалаа хадгалан амьдрах ёстой.

Ийм үзэл баримтлал нь ирээдүйд чиглэсэн байхын тулд малчдад байгаль хамгааллын ёс журмын дагуу амьжиргаагаа залгуулах хэрэгтэйг ойлгуулах, жишээлбэл, байгалиа хадгалан авч үлдвэл эргээд тэр нь эдийн засгийн үр өгөөжөө өгөх гэх мэт. Өнгөрсөн онд Дархан цаазат газрын хэмжээг 18,000 км² (Швейцар улсын талбайн бараг тал хувь) хүртэл өргөжүүлсэн тул үүнд урьд өмнөхөөс илүү олон хүн ажиллуулах шаардлагатай болсон юм.

Учир нь бэлчээрийн өрсөлдөөн, бог малаас халдвар авах эрсдэлтэй байгаа нь зэрлэг туруутан амьтдын хувьд асуудал болж магадгүй юм. Устгалаас болж генийн сан нь нилээд багассан тахь нь эрлийзжэх аюулд ч өртөж болзошгүй байна.

Дархан цаазат газрын удирдлагын хувьд, ялангуяа тухайн газрын шинээр хамгаалалтанд авсан бүсэд хүний нөлөөллийг хянах нь томоохон бэрхшээлтэй тулгарсан хэвээр байна. Тийм учраас бид хүн ба зэрлэг амьтдын зэрэгцэн оршихуйг оновчтой болгох зорилгоор 200 гаруй нүүдэлчин гэр бүлд тэдний амьдрал, өдөр тутмын ажлын талаарх нарийн зураглал гаргахын тулд захидлаар хандсан билээ. Монгол Улсын Засгийн газрын зүгээс тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалахад орчны бүсэд аж амьдралаа авч яваа малчдад тодорхой хариуцлага хүлээлгэхийг эрмэлзэж байна. Малчидтай нэг талаас газар нутаг ашиглах нөгөө талаас малын тоо толгойнд хязгаар тавих, бэлчээр, ургамал болон зэрлэг амьтдыг хамгаалах үүргийг тусгасан гэрээ байгуулснаар энэхүү зорилгод хүрэх боломжтой юм.

Тахийн мэдээ сонингоос таны өгсөн хандив устгах аюулд орсон амьтдад болон нүүдэлчдийн уламжлалт соёл уялдан зэрэгцэн оршиход чиглэсэн ажилд хэрхэн тус болж байгааг та олж мэдэх болно. Харамгүй өөрийн зүрх сэтгэлээ энэхүү ажилд зориулж буй багийнхаа гишүүдийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн дэмжлэг үзүүлсэн танд талархал илэрхийлье. Швейцар улсаас 6100 км зайтай хол газар орших ГИДЦГ-ын "Б" хэсэг нь одоо ч гэсэн олон нууц агуулсан хэвээр байна. Хатуу ширүүн уур амьсгалтай ч уудам сайхан тал нутгийг хойч үедээ энэ нутгийн үнэт дүр болох тахийн хамт онгон хэвээр нь үлдээхийг хүсдэг хүмүүс олон байгаа нь сайн хэрэг юм. Байгаль болон хүмүүсийн ирээдүйн төлөө ихийг бүтээх хүсэл эрмэлзэлтэй анд нөхдүүд бидэнд хэрэгтэй байна. Та бидэнтэй хамтрах уу?

Др. Райнхард Шнидрих, Олон Улсын Тахь Группын Ерөнхийлөгч



Говийн шим мандлын их нөөц газрын ирээдүйн төлөө орон нутгийн иргэд байгаль хамгааллын дүрэм журмын дагуу амьжиргаагаа залгуулах ёстой юм.

Малчид байгаль хамгаалагч байх боломжтой юу?

“Тахь манай ямааны бэлчээрийг талхлаж байна!” гэж саяхан нэгэн малчин ГИДЦГ-ын “Б” хэсгийн төвд орших бэлчээрээс тахийн сүргийг хөөсөн байна. Зарим малчдын үзэж байгаагаар бол бэлчээрийг зөвхөн тэдний мал л ашиглах ёстой ба зэрлэг туурайтан амьтад бол өрсөлдөгч тул тэднийг хол байлгах ёстой гэж үзэж байна.

Энэ нь бидний санааг зовоох бас нэг асуудал болж байна. Ялангуяа бог малын тоо толгой зэрлэг амьтдын тоо толгойноос хэд дахин давж, хурдацтай өсөж байгаа энэ үед Дархан цаазат газар дахь бэлчээрийн даац хэт их ачаалалттай байгаа нь мөн сэтгэл түгшээж байна. Өнгөрсөн жил хур тунадас ихтэй байсан ч энэ хавар өвс ногооны гаралт муу байгаа бөгөөд дархан цаазат газрын удирдлагуудын хэлж байгаагаар их хэмжээний цас ороход л Хонин ус баянбүрд орчим амьдардаг тахийн сүрэг тэжээлийн ноцтой хомсдолд орох аюултай гэжээ.

Нүүдэлчид өөрсдийн мал бэлчиж буй газар нутгийг үр шимтэй байлгахын тулд бэлчээрээ сэлбэж амрах хүсэл эрмэлзлэлтэй байдаг. Тийм учраас л малчид хэдэн зуун хонь, ямаа болон хэдэн арван адуугаа бэлчээр үр шимгүй болоход өөр газар луу үргэлжлүүлэн нүүдэл хийдэг юм. Гэхдээ зөвхөн бэлчээр доройтсон шалтгаанаас гэсэн үг бас биш ба үүнд нарийн учир байдаг юм. Мөн өнөө үед өөрийн хэрэгцээг хангадаг уламжлалт нүүдлийн мал аж ахуйн соёлд хэрэглээн дээр үндэслэсэн эдийн засаг хурдацтай нэвтэрч байна (2020 оны 12-р сарын 13-ны Тахийн мэдээ сонингийн дугаараас үзнэ үү).

Шим мандлын нөөц газарт нүүдэлчид болон ховордсон зэрлэг амьтад зэрэгцэн орших боломжийг хэвээр нь хадгалахын тулд хонь, ямааны тоо толгойд хязгаар тогтоож, малчдын дунд тодорхой зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай юм. 18 000 кв. км бүхий тусгай хамгаалалттай

газрын дүрэм журам бүрэн сахиулах нь амар ажил биш гэдгийг Байгаль орчны яамны зүгээс ойлгодогч газар дээрээ хэрэгжүүлэх нь амар биш. Энэхүү том талбайд эргүүл хийхэд дархан цаазат газрын цөөн тооны байгаль хамгаалагчдаас ихээхэн хүчин чармайлт шаардагдах болно.

Ноос ноолуур нь өнөөгийн малчдын орлогын гол эх үүсвэр болсон, иймд ноос ноолуураа зуучлагч нарт зарах бус орон нутагтаа боловсруулж борлуулснаар илүү орлого боломжтой билээ. Нэмүү өртөг мэдэгдэхүйц нэмэгдсэнээр ноолуурын чиглэлийн ямааны тоо толгойг хэт их өсгөхгүй байх хөшүүрэг болох юм. Энэ асуудлыг шийдэх гарц олох явдал нь Германы биологич, докторант Лена Михлерийн эрдмийн зэрэг хамгаалах ажлын үндсэн сэдэв юм. Үүний зэрэгцээ тэрээр ОУТГ-ийн¹ санхүүжилтээр гадаадын жуулчдад зориулсан аялаллуудыг хөгжүүлэх саналуудыг боловсруулах боломжийг судалж байна. Орон нутгийн иргэдэд илүү их нэмүү өртөг бий болгох боломжийг олгох нь ГИДЦГ-ын “Б” хэсгийн гол асуудлуудын нэг болоод байгаа юм.

Ирээдүйд хэрэв малчдыг ДЦГ-ын байгаль хамгаалагчидтай хамтран ажиллах ажилд татан оролцуулж чадвал тэд байгаль хамгаалах ажилд чухал хувь нэмэр оруулах боломжтой юм. 2019 онд Лена Михлер малчдад гучин ширхэг дижитал камер тарааж өөрсдөөр нь ажиглалтын дэвтэр хөтлүүлэх ажлыг эхлүүлжээ. Эдгээр ажиглалт нь дархан цаазат газрын удирдлага, судлаачдад зэрлэг амьтдын тархалт, амьдралын хэв маяг, орон зайг ашиглах талаар чухал мэдээлэл өгдөг юм. Ингэснээр малчид сайн дурын байгаль хамгаалагч нар болж, дэлхийн экосистемийг хамгаалахад чухал хувь нэмэр оруулж чадна.

¹ Michler L et al.: Орон нутгийн малчид болон ГИДЦГ “Б” хэсгийн хамгаалалтын захиргааны хамтын ажиллагааны менежментийн стратегийн талаар (ITG судалгааны төсөл No4). Бэлтгэх шатанд

Малчдын ажиглалтынхаа явцад авсан зураг. Цоохор ирвэс нь (Panthera uncia) ууланд амьдардаг ховордож буй гол төрөл зүйл боловч бусад муурнуудын төрлүүдийн адил дасан зохицох чадвартай байдаг.
Зураг: © Баяр Хадбаатар



Малчдын хийж байгаа ажиглалт нь тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг оновчтой болгох, улмаар тус нутгийн амьтан, ургамлаас дутахааргүй тэд өөрсдөө хамааралтай байдаг экосистемийг хадгалахад тус дэм болдог байна.

Төлөвлөлт, хамгаалалтын талаар

310,000 км² талбай бүхий дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар гээд Монгол Улс нийт газар нутгийнхаа 20 орчим хувийг хамгаалалтанд авсан байна. Тийм учраас Монгол улс нь 2010 оны Aichi-гийн зорилтуудын хэрэгжилтийн тэргүүнд явж байгаа юм. 2021 оны 10-р сард БНХАУ-ын Куньмин хотод дэлхийн биологийн олон янз байдлыг хадгалах шинэ зорилтуудын талаар хийхээр төлөвлөж буй хэлэлцээний хүрээнд биологийн олон янз байдлын тэргүүлэх чиглэлийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. 2030 он гэхэд дэлхийн хуурай газар ба далай тэнгисийн дор хаяж 30%-ийг биологийн олон янз байдлыг хамгаалж хадгалахад ашиглах ёстой юм; одоогоор тус тус зөвхөн 16.4 болон 7.7 хувь байгаа юм¹.

Гэхдээ энэхүү том зорилт нь зөвхөн тунхаглалаар биеллээ олдоггүй юм. Та ч бас үүнийг хэрэгжүүлэх ёстой. Булгийн эх нь булингартай бол адаг нь булингартай гэдэг зүйр цэцэн үгийн адил эхнээсээ зөв төлөвлөж хамгаалах ёстой билээ.

Уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж байгаа энэ үед энэ асар том талбайтай газар нутгийг хулгайн ан, хууль бусаар ашигт малтмал олборлох, ой мод устгах, бэлчээрийн даац хэтрэхээс хэрхэн яаж үр дүнтэй хамгаалах вэ? ГИДЦГ-ын “Б” хэсгийн талбай хоёр дахин нэмэгдээд хоёр жил болоогүй байгаа ч ОУТГ нь энэ асуултыг ХЗ-ын хамт тавьсаар ирсэн.

Жил бүрийн 1-р сарын сүүлээр зохиогддог хэлэлцүүлгийг энэ жил бид цахим хэлбэрээр хийсэн бөгөөд дээр дурдсан асуудлыг Монгол болон Европын түншүүдтэйгээ хамтран хэлэлцсэн билээ. ОУТГ, Дархан цаазат газрын удирдлага болон Байгаль орчны яам хамтран стратегийн болон үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлсон. Нэг талаас амьдрах орчны томоохон орон зай шаарддаг тахь, хулан болон бусад зүйлүүдийн амьдрахад тааламжтай газруудын сүлжээ бий болгох, нөгөө талаас нийгэм эдийн засгийн хөгжилд дэмжлэг болгох зорилгоор орон нутгийн иргэдийн идэвхтэй оролцоо бидний хувьд маш чухал хэвээр байна. Энэ нь дархан цаазат газрыг хүлээн зөвшөөрүүлэхэд шаардлагатай бөгөөд зэрлэг түрүүтан амьтдыг бэлчээрийн хомсдол болон эрлийзжүүлэхээс хамгаалахад хэрэгтэй юм.

(Үргэлжлэлийг зүүн гар талаас)

Зураг: © Болор-Эрдэнэ

¹ Монгол, Швейцар зэрэг 50 орон нэгдэж, Өндөр амбицын эвсэл (НАС) байгуулав, ялангуяа газар нутгийг хамгаалах томоохон зорилтыг амжилтанд хүрэхэд нь туслал зорилготой. Гэсэн хэдий ч дэлхийн хамгийн том арван орны 9 нь ОХУ, АНУ, Хятад, Бразил, Австрали, Энэтхэг, Аргентин, Казахстан, Алжир гэсэн улсууд НАС -г нэгдээгүй байгаа тул энэ нь тийм ч амар биш байх болно. Энэ улсууд хамтдаа дэлхийн мөсгүй гадаргуугийн 46% -ийг эзэлдэг.

Мөн бид тусгай хамгаалалттай газрын мэргэжлийн удирдлагын гол шаардлага болох боловсон хүчний нөөцийн хөгжлийн асуудал дээр маш их санаа зовниж байдаг. Тусгай хамгаалалттай газрыг өргөтгөсөнтэй холбогдуулан 2020 онд 14 гэрээт байгаль хамгаалагч нэмж ажилд авсан. Дархан цаазат газрын бусад ажилтнуудын адил тэдэнд холбогдох тоног төхөөрөмж болон дэд бүтэц, мөн сургалтанд хамрагдах болон мэргэжил дээшлүүлэх шаардлагатай байгаа юм.



Алтай суманд (Ховд аймаг) баригдахаар төлөвлөгдөж буй захиргааны болон мэдээллийн төвийн барилгын зураг төслийг инженер, архитектор Франц Михлер (Герман улс, Бад-Зекинген хот) үнэ төлбөргүй эхний байдлаар гаргаж өгсөн юм. ОУТГ-ийн төлөө гаргасан энэ их өгөөмөр хандивд бид их талархаж байна.

Үүний тулд бид зохион байгуулалтын бүтэц болон сургалтын хөтөлбөр боловсруулах тал дээр холбогдох яамтай хамтран ажиллаж байна.

Дархан цаазат газрын талбайг ихээр өргөтгөж байгаа нь маш том боломж боловч түүнийг дагаад Тахийн тал дахь алслагдсан хамгаалалтын захиргааны байрнаас удирдахад хүндрэл учирж байна. Тийм учраас энэхүү байрыг суурин бааз болон судалгааны газар хэвээр үлдээж дархан цаазат газрын захиргааг ГИДЦГ-ын хойд хязгаарт орших Алтай суманд (Ховд аймаг) баригдах хамгаалалтын захиргааны болон мэдээллийн төвийн байранд шилжүүлэн нүүлгэх төлөвлөгөөтэй байна. Ингэснээр дэд бүтэцтэй холбогдох, дархан цаазат газарт ажиллах ажилтнуудын ажлын байрыг илүү тухтай болгох, нэмэгдэж буй хэрэгцээнд зохицон дасахад сайнаар нөлөөлөх юм. Шинэ байр нь ажлын өрөө, хурлын заал, лаборатори, зочдын өрөө болон мэдээллийн төвтэй байх бөгөөд орон нутгийн иргэд болон жуулчдын зочлох газар байх ба байгаль орчноо хамгаалах үзэл санааг улам гүнзгийрүүлэх зорилго агуулах юм. Энэ нь бидний урт хугацааны зорилго болох шим мандалын дархан цаазат газрын үйл ажиллагаа болон санхүүгийн менежментийг ирээдүйд Монголын тал дангаараа бүрэн хариуцуулахад нэгэн хэсэг болно.

Тахь, хулан болон бусад зүйлийн амьдрах орчны сүлжээ газрыг байгуулах, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь бидний хувьд нэн чухал асуудал хэвээр байна.

ДЦГ-ын шинэ хилийг тодорхойлох 100 багана

Нэмж 9 мянган кв.км газрыг дархан цаазат хамтгаалалттай газар болгосон нь юуны түрүүнд байгальд ээлтэй хүн бүрт барьж байгаа том бэлэг юм. Харин үүний дараа нь хил хязгаар тогтоох зэрэг их ажил байсан. Зөвхөн шинэ хил хязгаараа тэмдэглэх ажилд л гэхэд 100 ширхэг бетонон багана, 3500 кг цемент, 65 литр будаг, 20 литр шингэрүүлэгч болон 29 ширхэг багс шаардлагатай байсан юм. Мөн будах, өрөмдөх, ухах, өргөх, шавардах ажлыг байгаль хамгаалагчид өөрсдөө хийж гүйцэтгэсэн билээ. Жан-Пьер, Соня Зигфридийн сангийн (<https://siegfried-takhi.ch>) харамгүй хандиваар энэ ажил нь дархан цаазат газрын шинэ хил хязгаарыг тэмдэглээд зогсохгүй Зүүнгарын говийг хамгаалахад чухал ач холбогдолтой ажил боллоо.



Гэхдээ үүгээр бүх ажил дууссахгүй юм. Тухайн газар нутгийг шинэчлэн бүсчлэл тогтоох, байгаль хамгаалагчдыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, сургах, эргүүл хийх, үүнд шаардлагатай тээврийн хэрэгслийн паркард автомашин нэмж авах, хэсэгчлэн шинэчлэх шаардлагатай байгаа бөгөөд дархан цаазат газарт амьдардаг орон нутгийн иргэдэд зориулж сумын төв болон сургуулиудаар дамжуулан мэдээллэл олгох кампанит ажил зохион байгуулах, дүрэм журам танилцуулах ажлууд бий. Эдийн засгийн хувьд тийм ч дээгүүр биш энэ бүс нутагт байгаль хамгаалах ажилд урам зоригтой шамдан орж, “сайн дурын байгаль хамгаалагчийн” ажилд хүмүүсийг татан оролцуулж, цаашид аялал жуулчлалын салбарт ажиллахад нь бэлтгэх хэрэгтэй байна.

Байгаль орчны талаарх мэдлэгийг дээшлүүлэх

Байгаль хамгаалах урт хугацааны ажилд залуу үеийнхнийг татан оролцуулах ёстой. Хотруу чиглэсэн нүүдэл эрчимтэй явагдаж байгаа энэ үед Монголын хувьд ч энэ асуудлыг шийдэх зайлшгүй шаардлагатай болж байна. Монгол орныг сайн мэддэг ОУТГ-ийн удирдах зөвлөлийн гишүүн хатагтай Анита Фарни үүнийг шийдэхийн төлөө байна. Тэрээр орон нутгийн өсвөр үеийнхэнд зориулан “Туяагийн аялал” нэртэй, маш сонирхолтой, олон сайхан зурагтай англи хэл дээр ном бичиж, 10 мянган ширхэгийг хэвлүүлж Улаанбаатар болон Баруун аймгуудын сургуулиудаар үнэгүй тараасан. Хотын охин Туяа байгаль хамгаалах төсөлд туслахаар ээжийнхээ хамт сурагчдын амралтын үеэр Тахийн тал руу явах ёстой болдог. Яаж явнаа гэж бодож байсан охин байгалийн үзэсгэлэнтэй газар очиж, тэндхийн ургамал, амьтантай танилцаж цагаа сайхан өнгөрүүлнэ.



Сурагчид “Туяагийн аялал”-ыг уншаад зөвхөн англи хэл сураад зогсохгүй онгон байгалиа хамгаалан авч үлдэхийн ач холбогдлын тухай мэдэж авна

100 ширхэг бетонон тулгуур нь дархан цаазат газрын хил хязгаарыг тэмдэглээд зогсохгүй Зүүнгарын говийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Хамтдаа Говийн төлөө

ГИДЦГ-ын “Б” хэсэгт холоос харагдах бужигнаж буй тоос нь гол төлөв хулангийн сүрэг давхиж байгааг илэрхийлдэг. Устах аюулд орсон азийн зэрлэг илжиг гэх хулангийн тоо толгой ойролцоогоор 10 мянга бөгөөд энэ нутаг тэдний сүүлчийн болон найдвартай орогнох газар болсон бөгөөд 2019 онд дархан цаазат газрыг өргөтгөснөөс хойш илүү сайн хамгаалалтанд орсон юм.



Зураг: ©Петра Каченски

Корона вирус тархсантай холбоотой хөл хорионы арга хэмжээ авч хэрэгжиж байгаа ч энэ жил болон цаашдаа ч бид менежментийн төлөвлөгөөнийхөө дагуу чухал ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна. Дархан цаазат газрын талбайн өргөтгөлтэй холбоотойгоор нилээд хэмжээний хүч чармайлт шаарддаг ажиглалт, хяналтын үйл ажиллагааны асуудал гарч ирж байна.

Одоогийн байдлаар ГИДЦГ-ын “Б” хэсэгт 22’000 орчим том түүрайтан амьдардаг бөгөөд үүний 300 нь тахь, 12’000 хулан, 10’000 цагаан зээр байна. 2020 онд хийхэр төлөвлөж байсан туруутан амьтдын тооллогыг нэг жилээр хойшлуулах шаардлагатай болов. Харин 2021 онд тооллого явуулж болох эсэх нь цар тахлын байдлаас хамаарах юм.

Цар тахал Говьд ч тарах болзошгүй тул тахийн хувьд ч мөн эрсдэл бий. Сүүлийн жилүүдэд нилээн өсөж байгаа боловч цөөн хэвээр байгаа тэдний хувьд цаг уурын эрсдэлд өртөөд зогсохгүй малын бэлчээрийн өрсөлдөөнд ч хохирч байна. Мөн тэд усалгааны цэгүүдэд бусад амьтнаас, ялангуяа гэрийн малаас халдвар авах магадлалтай юм; жишээлбэл, адууны герпесийн вирус нь усанд халдварлах чадвараа хадгалдаг². Бид энэ аюулын эсрэг түргэн бөгөөд шийдэмгий арга хэмжээ авах ёстой. Зэрлэг амьтдын өвчлөл, үхлийн шалтгааныг эрт үе шатанд нь тодорхойлохын тулд малын эмч (тухайлбал Ж.-М. Хатт), зэрлэг байгаль хамгаалагч нартай хамтарсан эмгэг судлалын семинар зохион байгуулах нь бидний хувьд маш чухал ач холбогдолтой юм.

Гэрийн адуутай эрлийзжэх явдал нь тахийн сүргийн хувьд ноцтой аюул учруулж болзошгүй байгаа бөгөөд энэ нь тэдний эмзэг, үнэт удмын санг ч устгаж болзошгүй юм. Коронавирусын улмаас манай генетикийн судалгааны ажил зогсонги байдалд ороод байсан. Харин одоо энэ чиглэлийн ажил үргэлжилж байгаа бөгөөд удахгүй үр дүн нь гарна гэж найдаж байна.

ГИДЦГ-ын “Б” хэсэгт ус ашиглалт, усны чанар болон усны менежментийг сайжруулах зорилгоор Швейцарын Хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Ховд Их сургууль болон дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай хамтран судалгаа хийгдэж байна. Гурван удаагийн үрт хугацааны хээрийн судалгааны явцад бид малчдаас ус ашиглалтын талаар асууж лавлаж, малын хөлд даруулахаас сэргийлж 8 бүлгийн эхийг хашсан юм. Судалгааг энэ онд хийж дуусгахаар ажиллаж байна. Одоогийн байдлаар нэмж хоёр цаг уурын

станц суурилуулах, бүлгийн эх хаших зэрэг хээрийн нэмэлт ажлууд хийгдэж байгаа юм. Нийт зардлын 10 хувийг ОУТГ хариуцан ажиллаж байна.

Мөн үүний зэрэгцээ биологич Лена Михлер орон нутгийн иргэд болон малчдын тогтвортой амьдрах нөхцлийг сайжруулах, шим мандлын дархан цаазат газраас өөр бусад үр өгөөж хүртэх нийгэм, эдийн засгийн боломжуудыг судалж байна.

ГИДЦГ-ын “Б” хэсгийн биологийн олон янз байдлын талаар илүү сайн ойлголттой болохын тулд бид биологийн олон янз байдлын каталог гаргахаар төлөвлөж байгаа. Каталоггоос мөн тус бүс нутагт бүртгэгдсэн 100 төрлийн шувуу, тухайн газрын экологийн хамгаалахад чухал ач холбогдолтой, түлшинд хэрэглэгдэхээс хамгаалагдах ёстой загийн бүт сөөгийг газрын зураг дээр харуулсан байх болно. Мөн ДЦГ-ын уулархаг хэсэгт Хятадын хил дагуу цоохор ирвэс болон ууланд амьдардаг туруутан амьтдын тоо толгойг гаргах зорилгоор Монгол улс дахь Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн хамт 100 ширхэг камер суурилуулсан. Түүнчлэн ОУТГ-ийн биологич Г.Ёндон, Ховдын Их сургуулийн доктор З.Бурмаагаар ахлуулсан багтай хамтран усны гидробиологийн судалгаа хийж байна. Усны сээр нуруугүй амьтдын судалгаанд одоогоор 6 багийн 25 овгийн амьтад илэрсэн байна. 5-р сараас эхлэн хөрсний микроартропод буюу хөрсний бичил үе хөлтний дээж авах ажил төлөвлөсөн байгаа. Мөн бид байгаль хамгаалахын өнөөгийн болон ирээдүйн зорилтуудад залуу судлаачдыг татан оролцуулах зорилгоор орон нутгийн их дээд сургуулиудтай хамтран оюутан солилцооны хөтөлбөр эхлүүлээд байна.



Зүүнгарын говийн ургамалын аймагт эрс тэс уур амьсгалд дасан зохицсон хаг болон цэцэгт ургамал багтдаг.

Зураг: ©Петра Каченски

^[2] Dayaram A et. al., Science of the Total Environment, 773, 2021, <https://doi.org/10.1016/j.scitotenv.2021.145446>

Энэ жил бид менежментийн төлөвлөгөөндөө тусгасан чухал ажлуудыг хэрэгжүүлэхээр шамдан ажиллаж байна.

Ургамлын зүйлийн хөрөг: Вансэмбэрүү (устах аюулд өртсөн)/ *Bogeda snow lotus* (IUCN: CR)

Эртний зэрлэг адуу болох тахь нь ГИДЦГ-ын “Б” хэсэгт хатуу хамгаалалтанд байдаг цорын ганц ховор зүйл биш юм. Анх 2018 онд тэмдэглэгдсэн ботаникийн салбарын судалгаа болох Вансэмбэрүү (*Saussurea bogedaensis*) нь бүр ч ховор тохиолдох ургамлын зүйл юм. *Saussurea* төрөлд багтсан энэхүү гайхалтай ургамал нь устаж үгүй болох аюулд орсон зүйл гэж Улаан жагсаалтад нэн даруй оруулах ёстой. Учир нь энэ зүйл нь дэлхийд зөвхөн хоёр газар л байдаг: Зүүн Тянь-Шанын Шинжан болон ГИДЦГ-ын “Б” хэсэгт.

Вансэмбэрүү нь бидний мэдэх зэс цэцгийн төрөл боловч *Daisy* овогт багтах (*Asteraceae*) өөрийн гэсэн дэд бүлгийг (*Carduoideae*) бүрдүүлдэг. Энэ цэцгийн төрлийн ерөнхий нэрийг Швейцарын байгаль судлаач Гораце-Бенедикт Де Соссюр (1740-1799, геологи, мөс судлал, уулын спортыг үндэслэгч, Монбланы маркшейдер) болон түүний хүү Николас Теодор де Соссюр (1767-1845, ургамлын физиологийн үндэслэгч) нарын нэрээр *Saussurea* гэж нэрлэсэн юм.

2013 онд тухайн үед биологийн чиглэлээр сүрч байсан Шүхэрдоржийн Баасанмөнх нь ГИДЦГ-ын “Б” хэсгээс цэцгийг илрүүлжээ. 2017 онд тэрээр мөн өөр нэг цэгийн тархалтыг олсон юм.

Гэхдээ энэ зүйлийг анх шинжлэх ухааны үүднээс нь 2018 онд Хятадын судлаач Юй Дж. Ванг болон Дж. Чен¹ нар дэлхийд шинэ зүйлээр бичсэн. 2020 онд Ш.Баасанмөнх нь бусад эрдэмтэдийн хамт Монголд ургадаг энэ нэн ховор зүйлийн генетикийн шинжилгээг хийсэн талаар нийтэлсэн байна². Энэ зүйл нь Тянь-Шанын (*Saussurea involucrata*) болон Алтайн (*Saussurea orgaadayi*) гэсэн өөр хоёр *Saussurea* зүйлтэй төсөөтэй холбоотой болохыг тэд тогтоож чаджээ. Гэхдээ энэ зүйл нь газар зүйн хувьд бусдаасаа тусгаарлагдсан бөгөөд морфологийн болон генетикийн хувьд ялгаатай юм. Монголд Вансэмбэрүү нь далайн түвшнээс дээш 2400-3300 метрийн өндөрт чулуурхаг, налуу нуруу болон голын эрэг дагуу ургадаг.

Saussurea (Банздоо) төрөл нь 6 дэд төрөл болон 500 орчим зүйлтэй бөгөөд Нийлмэл цэцэгтний овгийн *Asteraceae* томоохон төрлүүдийн нэг юм. Банздоо төрөл нь дэлхийн бөмбөрцөгийн хойд хагаст янз бүрийн амьдрах орчинд, ялангуяа сэрүүн болон хуурай өндөрлөг газар ихээр тархсан байдаг. Жишээ нь Хятадад л 317 зүйл, Энэтхэгт 61, Сибирыг 54, Бутанд 41, Пакистанд 23 төрөл бүртгэгдсэн байна. Монголд одоогоор 53 зүйлийн *Saussurea* бүртгэгдсэн бөгөөд үүнээс 5 зүйл нь унаган буюу эндемик, өөрөөр хэлбэл зөвхөн Монголд ургадаг (энэ мэдээллийн дагуу⁴). *Saussurea* төрлөөс гаргаж авсан эфирийн тосыг янз бүрийн зориулалтаар, голчлон эмчилгээний болон шашны зорилгоор, мөн үнэртэй ус болон шавьж устгах бодис үйлдвэрлэхэд ашигладаг.

^[3] *Saussurea bogedaensis* Yu J.Wang & J.Chen, *PLoS ONE* 13(7): e0199416 (12) (2018)

^[4] Baasanmunkh, Shukherdorj, Nyamgerel, Nudkhuu, Bayarmaa, Gun-Aajav, Oyuntsetseg, Batlai, Oyundelger, Khurelpurev & Choi, Hyeok Ja, 2020, A new record of critically endangered *Saussurea bogedaensis* (Asteraceae) from Dzungarian Gobi, Mongolia, *PhytoKeys* 160, pp. 109-121: 109; <http://dx.doi.org/10.3897/phytokeys.160.55603>



Устах аюулд ороод байгаа нэн ховор зүйл: Вансэмбэрүү нь дэлхий дээр зөвхөн 2 газар тохиолдох бөгөөд нэг нь ГИДЦГ-ын “Б” хэсэг юм. Зураг: ©Шүхэрдоржийн Баасанмөнх

Энэ нь *Saussurea*-ын хэдэн төрлийг хэт ихээр ашиглахад хүргэж үүнээс үүдэн амьдрах орчныг нь устах аюулд хүргээд байна. Энэ төрлийн ургамал нь маш ховор болон бага нөөцтэй тааралддаг тул зохисгүй хэрэглээ нь тус ургамлын оршихуйд маш том аюул учруулж болзошгүй юм.

Вансэмбэрүү цэцгийн хоёр төрөл болох Вансэмбэрүү (*Saussurea involucrata*) болон *Saussurea orgaadayi* хамаарагддаг бөгөөд хоёулаа Монгол улсын улаан жагсаалтад багтсан байдаг юм.

Илүү ховорд тооцогдох Вансэмбэрүүгийн хэрэглээ нь түүнийг устаж үгүй болгох эрсдэлд хүргэж болох юм. Өнөөдрийг хүртэл Монголд ГИДЦГ-ын “Б” хэсэгт зөвхөн хоёр зүйлийг нээн илрүүлсэн бөгөөд нийтдээ 600 хүрэхгүй ургамал тогтоогдсон байна. Тиймээс уг зүйл нь хүний хүчин зүйлийн нөлөөгөөр устаж үгүй болох (санаатай эсвэл санамсаргүй) том аюулын өмнө тулгараад байна. Монголын болон Хятадын судлаачид уг зүйлийг Дэлхийн Улаан Дансын шалгуураар устах аюулд (CR) өртөөд байна гэж үнэлсэн байдаг. Үүсээд байгаа эрсдэлд илүү сайн үнэлгээ өгөхийн тулд Вансэмбэрүү цэцгийн үржлийн биологийн судалгааг хийх шаардлагатай байна. Ялангуяа ямаан сүрэг энэ төрөлд онцгой аюул учруулж байгаа юм. Тиймээс энэ ургамлын тархалтын бүсийг хатуу хамгаалалттай бүс болгож малын бэлчээрээс тусгаарлах ёстой.

Тахь адууны батлгаат ирээдүйг хамтдаа бий болгоё



“ГИДЦГ-ын “Б” хэсэг дахь усны нөөц болон баянбүрдүүд нь тахь болон бусад амьтдын амьдралын хувьд маш чухал юм. Бидний явуулсан гидробиологийн судалгааны ачаар энэхүү эмзэг байгалийн тогтолцоог анх удаа илүү сайн ойлгох болсон. Зөвхөн ингэснээр бид тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг үрт удаан хугацаанд хадгалан хамгаалах талаар зөв шийдвэр гаргаж чадна.”

Гансүхийн Ёндон, биологч, ОУТГ-ийн эрдэм шинжилгээний баг (Монгол улс)

Таны хандив бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Хандивын бүх мөнгө зэрлэг адуу тахь болон Төв Азийн тал хээрийн өвөрмөгц ургамал, амьтныг хамгаалахад туслах болно. Танд баярлалаа!

150,000 төгрөг

Таны хандиваар тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн олон янз байдлын талаар орон нутгийн иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 4 ширхэг мэдээллийн постер, 20 ширхэг гарын авлага хэвлэгдсэн байна.

225,000 төгрөг

Та тусгай хамгаалалттай газрын усны тогтвортой байдлын менежментийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг мэдээллийн санг бий болгоход тусалж байна.

300,000 төгрөг

Та шинээр ажилд орсон байгаль хамгаалагчийг хэрэгцээтэй тоног төхөөрөмжөөр хангахад хувь нэмэр оруулж байна.

600,000 төгрөг

Та зэрлэг амьтдын эмгэгийг хурдан шүүрхай тодорхойлох боломжийг олгодог эмгэг судлалын семинарыг санхүүжүүлэхэд туслах болно.



Зургийг С.Далайцэрэн

Та “Тахийн найз нөхөд” болох уу?

- Хувь хүний гишүүнчлэлийн жилийн хураамж **130,000 төгрөг**
- Оюутан, залууст зориулсан “Унага” гишүүний хураамж **50,000 төгрөг**

Биднийг [Facebook](#) [Instagram](#) дээрээс дагаарай  

Хандивын данс

Олон Улсын Тахь Группын Монгол дахь товчоо
ХХБ
499114883 ам. долл.
499248691 төгрөг

Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв. FSC
(Ойн Удирдах Зөвлөл) / EХ Эко шошгоны цаас



Эрхлэн гаргасан

ITG International Takhi Group
Friends of the Wild Horse
c/o Stiftung Wildnispark Zurich
Alte Sihltalstrasse 38
CH-8135 Sihlwald / ZH
www.savethewildhorse.org
info@savethewildhorse.org
itg.ulaanbaatar@gmail.com